

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia-аас татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 17:30 хүртэл
- Хүлээн авах хаяг: munkhsarnai@mddic.gov.mn
- Холбоо барих утас: 266212

Шилжүүлэх, сэлгэн авах ажлын байрны жагсаалт:

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	Төсвийн ерөнхийлөн захирагч, салбар болон харьяа байгууллагын хүрээний дотоод аудит хариуцсан ахлах шинжээч	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Ахлах түшмэл ТЗ-4	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	-Нягтлан бодох бүртгэл, татвар (041101); -эдийн засаг (0311); -санхүү, банк, даатгал (0412).	-Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх;	- Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.
2.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Хиймэл оюун, их өгөгдлийн хэлтэс	Их өгөгдөл, хиймэл оюуны дэд бүтцийн төлөвлөлт хариуцсан шинжээч	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Ахлах түшмэл ТЗ-5	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	-Өгөгдлийн сан, сүлжээний загварчлал ба удирдлага (0612); -программ хангамж, түүний хэрэглээ хөгжүүлэлт ба шинжилгээ (0613); -мэдээлэл харилцаа холбооны технологиудад ангилагдаагүй чиглэл (0619);	- Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх;	- Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.

								-электроник, автоматжуулалт (0714).		
3.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	Харилцаа холбоо, кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	Дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	1	Төрийн захиргааны гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;	-Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд (061903); - электроник, автоматжуулалт (071406, 071407, 071408, 071412); -менежмент ба удирдахуй (041303).	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуутал болно.

---o0o---